

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Банк бус санхүүгийн салбар нь эхний хагас жилийн байдлаар тусгай зөвшөөрөлтэй 536 ББСБ нь давхардсан тоогоор 21,486 хувьцаа эзэмшигчтэй, 308 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 3,713 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 3.3 сая харилцагч, 748.3 мянган зээлдэгчид санхүүгийн үйлчилгээ үзүүлж байна. Салбарын статистик үзүүлэлтүүд нь сүүлийн 5 жилийн хугацаанд эрчимтэй нэмэгдэж нийт харилцагчдын тоо 119 хувиар, зээлдэгчдийн тоо 167,8 хувиар, нийт актив 121.5 хувиар, зээл 166.0 хувиар тус тус өссөн байна.

Мөн Монгол Улсын санхүүгийн салбарт тэр дундаа банк бус санхүүгийн салбарын хөгжил нь финтек буюу санхүүгийн технологитой салшгүй холбоотойгоор тодорхойлогдож байна. ББСБ-ын салбарт технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ буюу финтекийг өргөнөөр нэвтэрч байгаатай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс энэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлж буй ББСБ-уудын хөгжлийг бодлогоор дэмжин ажиллаж байгаа бөгөөд 2021 оны эхний хагас жилийн байдлаар 22 ББСБ дэвшилтэд технологид тулгуурлан аппликэйшн ашиглан зээл олгож байна.

Технологид суурилсан санхүүгийн шинэ үйлчилгээ бий болж, салбарын харилцагч үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэхийн хэрээр үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалсан, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар иргэдэд хүрэх санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн, төрөөс үзүүлж буй тусгай зөвшөөрлийн тоог бууруулсан, салбарын хөгжлийн чиг хандлагыг олон улсын жишигт нийцүүлсэн хууль эрх зүйн орчинг бий болгох зайлшгүй нөхцөл байдал энэхүү банк бус санхүүгийн салбарт тулгараад байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль нь анх зохицуулагч байгууллага болох Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдахаас өмнө 2002 оны 12 дугаар сарын 12-нд батлагдсан бөгөөд батлагдснаас хойш нийт 9 удаа бусад хууль тогтоомжийн нийцэлтэй уялдуулан нэмэлт өөрчлөлт орсон байдаг.

Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн байгууллагын салбарын үйл ажиллагаанд нэн тааламжтай орчинг бий болгох, санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх замаар санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, салбарын хөгжлийг олон улсын жишигт хүргэх, хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, салбарыг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зарчмын томоохон асуудлыг тусгаж өгсөн. Үүнд:

1. **ББСБ нь олон талт санхүүгийн үйлчилгээг эрхлэх боломж бүрдэнэ.** Өөрөөрхэлбэл салбарын оролцогч нь 4 тусгай зөвшөөрлийн хүрээнд 11 санхүүгийн үйлчилгээг тусгайлсан зөвшөөрөл авахгүйгээр эрхлэх боломжтой болно. Одоогийн эрх зүйн зохицуулалтаар банк бус санхүүгийн 11 үйл ажиллагааг 11 тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байгаа бол энэхүү шинэчилсэн хуулийн төслөөр тусгай зөвшөөрлийн тоог 60 хувиар

бууруулж, ББСБ нь 4 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд хуулиар зөвшөөрөгдсөн 11 үйл ажиллагаанаас гадна, Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөгдсөн санхүүгийн үйлчилгээг эрхлэх эрх зүйн зохицуулалт бий болно.

2. **Салбарын оролцогчдыг чадавхижуулж, төрөлжсөн институт болгоно.** Хуулийн төслийн зохицуулалтад ББСБ-ыг эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр нь “Зээлийн банк бус санхүүгийн байгууллага”, “Хөрөнгө удирдлагын банк бус санхүүгийн байгууллага”, Факторинг, “Валют арилжаа” гэж ангилахаар тусгасан. Зээлийн банк бус санхүүгийн байгууллага нь зээл, санхүүгийн түрээс, баталгаа батлан даалт гаргах, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, валют арилжаа эрхэлнэ. Харин “Хөрөнгө удирдлагын банк бус санхүүгийн байгууллага” нь дээрх үйл ажиллагаанаас гадна итгэлцлийн үйл ажиллагаа эрхэлнэ. Ингэж ББСБ-уудыг төрөлжүүлснээр салбарын оролцогчдын санхүү, төлбөрийн чадвар сайжирч, улмаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ББСБ-уудын макро эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлнэ.
3. **Финтект суурилсан санхүүгийн үйлчилгээний эрх орчин бий болно.** Монгол улсад шинэ дэвшилтэд технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ эрчимтэй хөгжийн хэрээр түүнийг зохицуулсан эрх зүйн орчин байхгүй байна. Энэхүү үйлчилгээ нь иргэд техник технологийг ашиглаж барьцаа хөрөнгө шаардахгүй, богино хугацаатай, бага хэмжээний зээлийг хялбар, түргэн, шуурхайгаар цаг, зардал хэмнэн хүү, нөхцөл багатайгаар авч байгаа боловч төрийн хяналт зохицуулалт байхгүй байгаагаас харилцагч нэгэн зэрэг олон байгууллагаас зээл авах улмаар өрийн дарамтад орох эрсдэлийг бий болгож байна. Иймд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд финтекийн талаарх анхны тодорхойлолтыг бий болгож, зохицуулалтыг бий болгохоор тусгасан.
4. **Компанийн засаглалын ил тод байдал, мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт бий болно.** 2021 оны эхний хагас жилийн байдлаар 108 ББСБ 486.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг жилийн 17.7%-ийн жигнэсэн дундаж өгөөж/хүүтэйгээр татан төвлөрүүлээд байна. ББСБ-уудын эх үүсвэр татан төвлөрүүлэх боломжийг нэмэгдүүлэхийн хэрээр засаглал, дотоод хяналтын механизмыг сайжруулах нөхцөл шаардлага бий болж байгаа тул ялангуяа Хөрөнгө удирдлагын банк бус санхүүгийн байгууллага нь заавал ТУЗ-тэй байх, түүний 1/3 нь хараат бус гишүүн байх, сонирхлын зөрчлөөс ангид байх, сонирхлын зөрчил үүссэн үед ТУЗ-д мэдэгдэг байх, ТУЗ-д тавигдах шаардлага зэрэг зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаж өгсөн. Ингэснээр ББСБ-уудын засаглалын ил тод байдал сайжирч, засаглалын сайн зарчмыг нэвтрүүлэх, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлнэ. Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь харилцагч, хөрөнгө оруулагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хуулиар зөвшөөрсөн гуравдагч этгээд буюу шүүх, прокурорын байгууллага зэрэгт гаргаж өгөхөөр хуулийн төсөлд тусгасан.
5. **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулна.** ББСБ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд бөгөөд зөвхөн энэхүү хуулийн зохицуулалтаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэхэд учир дутагдалтай байна. Иймд хуулийн

төсөлд банк бус санхүүгийн үйл ажиллагаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлсэн зохицуулалтыг тусгаж өгсөн. Тухайлбал, итгэмжлэгч нь итгэмжилсэн хөрөнгийн эцсийн өмчлөгч байх ба хөрөнгийн гарал үүслийг итгэмжлэгдэгч шалгадаг байхаар, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагааг зөвшөөрөлгүй этгээдээр дамжуулан гүйцэтгэх, бэлэн мөнгөөр шилжүүлэг хийхийг хориглосон зохицуулалтыг тусгасан.

6. **Зохицуулагч байгууллагын эрх үүргийг тодорхой болгож, нэгдсэн хяналт шалгалт хийх эрх орчин бүрдэнэ.** Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль нь зохицуулагч байгууллага болох Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдахаас өмнө батлагдсан бөгөөд салбарын хөгжлийг даган зохицуулагч байгууллагын хяналт, зохицуулалтын тогтолцоог хууль эрх зүйн хувьд тодорхой болгох, төрийн байгууллагуудын нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл шаардлага бий болсон. Банк бус санхүүгийн салбарт үндэсний томоохон компаниудын охин компани үйл ажиллагаа явуулж байгаагаас тэдгээр нэгдлийн оролцогчдыг төрийн нэгдсэн хяналт шалгалтын хүрээнд хянах, зохицуулах зайлшгүй нөхцөл байдал үүсээд байна. Иймд хуулийн төсөлд зохицуулагч байгууллагын бүрэн эрх, үүрэг, нэгдсэн хяналт шалгалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаарх зохицуулалтыг нарийвчлан тодорхойлж өгсөн.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан томоохон зарчмын өөрчлөлтүүдийг дээр дурдсан бөгөөд хуулийн сайжруулах, бусад хууль тогтоомжтой нийцүүлэх, ялангуяа Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон бусад хэрэгжилтэд хяналт тавьдаг хууль тогтоомжтой нийцүүлэх зэрэг өөрчлөлтүүд хуулийн төсөлд тусгагдсан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧИД

----000----